



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Б.Ширэндэвийн гудамж 8/4, Засгийн газрын V байр.  
Утас/Факс: (976-51) 26 75 33, И-мэйл: info@tojha.gov.mn,  
Вэбсайт: www.tojha.gov.mn

2021.08.12 № 1/3479

танай 2021.07.27-ны № 03/3289-Т

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙД Л.ХАЛТАР ТАНАА

Зам, тээврийн хөгжлийн сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/101 дүгээр тушаалыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн ...5430... дугаарт, “Журам батлах тухай” 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А/116 дугаар тушаалыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн ...5431... дугаарт тус тус бүртгэснийг үүсгэж



151603760  
А5 Файл.2021



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2021 оны 08 сарын 13-ны  
өдрийн 5430 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/101.

Улаанбаатар хот


Журам шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Зам, тээврийн салбарын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулсантай холбогдуулан "Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын тусгай зөвшөөрөл олгох журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 131 дүгээр тушаал болон Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/123 дугаар тушаалыг тус тус хүчингүй болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т даалгасугай.





Зам, тээврийн хөгжлийн сайдын  
2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн  
А/101 тоот тушаалын хавсралт

**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ,  
ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИХ, АРЧЛАХ, ЗАСВАРЛАХ, ТЕХНИК,  
ТЕХНОЛОГИЙН ХЯНАЛТ ТАВИХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ**

***Нэг. Нийтлэг үндэслэл***

1.1. Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл /цаашид “тусгай зөвшөөрөл” гэх/-ийг шинээр олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, нөхөн олгох, хүчингүй болгох, хяналт тавих харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Авто замын тухай хууль болон энэхүү журмаар зохицуулна.

1.3. Тусгай зөвшөөрөл шинээр олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, нөхөн олгох, хүчингүй болгох асуудлыг Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэж, хууль тогтоомжийн дагуу хяналт тавина.

1.4. Тусгай зөвшөөрөл шинээр олгох болон сунгах хүсэлт гаргах, бүртгэх үйл ажиллагааг цахим системээр дамжуулан хэрэгжүүлнэ.


1.5. Тусгай зөвшөөрөл шинээр олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон мэдээлэл олон нийтэд ил тод, нээлттэй байна.

1.6. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр олгосон тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд Авто замын тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлнэ.

1.7. Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны аж ахуйн нэгжээс хүсэлт хүлээн авч дүгнэлт гаргах, бүртгэл мэдээллийг эрхлэх хөтлөх үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр мэргэжлийн төрийн бус байгууллагад шилжүүлэн гүйцэтгүүлж болно.

***Хоёр. Тусгай зөвшөөрөл авах аж ахуйн нэгжид тавигдах ерөнхий шаардлага, тусгай зөвшөөрлийн төрөл, ангилал***

2.1. Тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт гаргагч нь Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд байна.



2.2. Тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгж нь эрхлэх үйл ажиллагааны төрлөөс хамаарч журмын хавсралтад заасан инженер, техникийн ажилтан болон холбогдох мэргэжилтэй ажилтантай байна.

2.3. 2.2-т заасан ажилтанууд нь тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжийн үндсэн ажилтан байна.

2.4. Тусгай зөвшөөрөл хүссэн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн инженер техникийн ажилчдын 70-аас доошгүй хувь нь дотоодын инженер техникийн ажиллагсад байна.

2.5. Машин механизм, тоног төхөөрөмж нь тухайн ангилалд тохирох ажлыг гүйцэтгэхэд технологийн бүрдэл, тоо хэмжээ, ашиглалтын шаардлага хангасан байна.

2.6. 2.5-д заасан машин механизм, тоног төхөөрөмж нь тусгай зөвшөөрөл хүсэж байгаа тухайн аж ахуйн нэгжийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй өөрийн өмчлөлийн машин механизм, тоног төхөөрөмжтэй байна.

2.7. Тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгж нь авто замын салбарт үйл ажиллагаа явуулахад мөрдөх Үндэсний стандарт, норм норматив болон бусад техникийн баримт бичгийн бүрдэлтэй байна.

2.8. Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны төрөл, ангилал

2.8.1. Техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд:

2.8.1.1 Техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах

2.8.1.2 Төв замын зураг төсөл боловсруулах

2.8.1.3 Хуримтлуулагч замын зураг төсөл боловсруулах

2.8.1.4. Хотын авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах

2.8.1.5 Хөдөө орон нутгийн замын зураг төсөл боловсруулах

2.8.1.6 Нисэх буудлын хөөрч буух зурвасын зураг төсөл боловсруулах

2.8.1.7 Гүүр, туннелийн зураг төсөл боловсруулах

2.8.2 Авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлах ажлын хүрээнд:

2.8.2.1 Хатуу хучилттай авто зам барих


*/Цементбетон, асфальтбетон, хөнгөвчилсөн хучилт болон тэдгээрийн их засварын ажил, 6 у/м хүртэлх гүүр, замын ус зайлуулах байгууламжууд/*

2.8.2.1.1 5 км хүртэл хатуу хучилттай авто зам барих

2.8.2.1.2 15 км хүртэл хатуу хучилттай авто зам барих

2.8.2.1.3 15 км болон түүнээс дээш хатуу хучилттай авто зам барих

2.8.2.2 Хайрган хучилттай авто зам барих



3.2.4 Үндсэн хөрөнгийн болон санхүүгийн тайлан /аудит хийгдсэн/

3.3 Дүгнэлт гаргах явцад шаардлагатай бусад баримт бичгийг шаардаж болно.

3.4 Шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгж, байгууллагын инженер-техникийн ажилтан, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник хангамжтай газар дээр нь танилцаж, ирүүлсэн материалыг хянан үзэж тусгай зөвшөөрлийг олгох дүгнэлт гаргана.

3.5 Тусгай зөвшөөрөл авахыг хүссэн аж ахуйн нэгж, байгууллагаас шаардлага хангасан баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу ажлын 21 хоногийн дотор шийдвэрлэнэ.

3.6 Энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заасан нөхцөл шаардлагыг хангасан хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай олгож, мөн хугацаагаар сунгаж болно.

3.7 Тусгай зөвшөөрлийн хүрээнд ажлыг зураг төсөл, техникийн шаардлага зөрчин чанаргүй хийсэн, гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоодсон аж ахуйн нэгжийн эзэмшигч, захирал болон ерөнхий инженерийн оролцсон аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл шинээр олгохоос татгалзана.

3.8 Цахим мэдээллийн санд бүртгүүлсэн мэдээлэл засвартай, зөрүүтэй, шаардлага хангаагүй нөхцөлд мэдээллийг буцаах ба мэдээллийн үнэн зөв бүрдэх хүртэл хүсэлт баталгаажихгүй.

**Дөрөв. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах, ангилал өөрчлөх, нөхөн олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох**

4.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлтийг хүчинтэй хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө цахим системээр дамжуулан гаргана.

4.2 Хүсэлтэд дараах материалуудыг хавсаргана.

4.2.1 Албан хүсэлт

4.2.2 Инженер техникийн ажилтны мэдээлэл


4.2.3 Мэргэжилтэй ажилчдын мэдээлэл

4.2.4 Машин механизм, тоног төхөөрөмжийн жагсаалтын мэдээлэл

4.2.5 Тусгай зөвшөөрлийн хүрээнд хийсэн ажлын мэдээллийг ажил гүйцэтгэх гэрээ, акт, бусад нотлох баримтын хуулбарын хамт

4.2.6 Үндсэн хөрөнгийн болон санхүүгийн тайлан /аудит хийгдсэн/

4.3 Тусгай зөвшөөрлийн хүрээнд ажил хийгээгүй бол тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзана.



4.4 Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулахаар хүссэн аж ахуйн нэгж нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.4-т заасны дагуу тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг зөрчсөн, энэхүү журмын 6.2-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзана.

4.5 Үйл ажиллагаа нь тогтвортой, 3-аас доошгүй удаа тусгай зөвшөөрөл нь хугацаандаа сунгагдсан, ямар нэг зөрчил гаргаж эрх бүхий байгууллагын дүгнэлт гарч байгаагүй, аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай сунгаж болно.

4.5 Тусгай зөвшөөрөлд ангилал нэмсэн тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацаа өөрчлөгдөхгүй.

4.6 Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээг гэсэн, үрэгдүүлсэн шалтгаанаар нөхөн олгуулах хүсэлт гаргасан бол гэрчилгээгээ гэсэн тухай өдөр тутмын сонинд зарлуулж, сонингийн хамт нөхөн олгох хүсэлтийг ирүүлнэ. Хүсэлтийг үндэслэн Авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр гэрчилгээг нөхөн олгоно.

4.7 Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн оноосон нэр өөрчлөгдсөн шалтгаанаар нөхөн олгуулах хүсэлт гаргасан бол аж ахуйн нэгжийн нэр өөрчлөгдсөн тухай улсын бүртгэлийн ерөнхий газрын лавлагаа, аж ахуйн нэгжийн шинэ гэрчилгээ, дүрмийн хуулбар болон хүсэлтийг үндэслэн Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр гэрчилгээг нөхөн олгоно.

4.8 Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13.1-д заасан үндэслэлээр 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно.

4.9 Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаа дуусгавар болсон тохиолдолд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13.3-т заасны дагуу шийдвэрлэнэ.

4.10 Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1-т заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.


#### **Тав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг**

5.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон ангиллын хүрээнд үйл ажиллагаа явуулна.

5.2 Хэрэв тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн инженер, техникийн ажилчид солигдсон бол шилжилт хөдөлгөөнийг цахим санд бүртгүүлнэ.

5.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж нь тухайн жилд гүйцэтгэсэн ажлын тайлан болон тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын талаарх мэдээллийг жилийн бүрэн 1 дүгээр улиралд багтаан ирүүлнэ.

5.4 Гүйцэтгэсэн ажлын тайлан болон тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын талаарх мэдээллийг мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтарсан



ажлын хэсэг хянан үзэж дүгнэлт гаргаж Авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

### **Зургаа. Бусад**

6.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж болон тэдгээрийн инженер техникийн ажилчид, хийсэн ажлын туршлагын мэдээллийг Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүнээс эрх олгосноор мэргэжлийн төрийн бус байгууллага эрхлэн хөтлөнө.



6.2 Тусгай зөвшөөрлийн хүрээнд ажлыг зураг төсөл, техникийн шаардлага зөрчин чанаргүй хийсэн, гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоодсон бол тухайн дүгнэлтийг аж ахуйн нэгжийн мэдээлэлд хавсарган хадгална.

6.3 Тусгай зөвшөөрлийн материалыг хуурамчаар үйлдсэн бол Зөрчлийн тухай хууль болон бусад холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.4 Тусгай зөвшөөрөл олгоход Улсын Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасныг баримтлан тэмдэгтийн хураамж авч, улсын төсөвт шилжүүлнэ.

6.5 Тусгай зөвшөөрөл олгох шаардлага хангасан аж ахуйн нэгж нь тэмдэгтийн хураамжийг төлнө.

6.6 Тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.3 –т заасныг зөрчин бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно. Ийм үйлдэл нотлогдсон тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүйд тооцно.



“Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үнэлгээ, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын тусгай зөвшөөрөл олгох журам”-ын хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖЛЫН ТӨРӨЛ, НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

Бүртг УЛААНБААТАР ХОТ.....  
МОН 2021 УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ  
ХУУЛБАР ҮНЭН  
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг  
*Самданова*  
2021 оны 07 сарын 28 ний өдөр

МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ  
ЭХ ХУВЬ  
Сайд Төрийн нарийн бичгийн  
дэргын 21 оны А/К/ дээр тусгай




**НЭГ.** Техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд:

Нийтлэг нөхцөл шаардлагыг хангахаас гадна дараах шаардлагыг хангасан байна.

Ажилбар	Шаардлагатай инженер техникийн ажилтан	Шалгуур үзүүлэлт
2.8.1.1. Техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах	Авто замын инженер-2	Аль нэг авто замын инженер нь мэргэжлээрээ 10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх зэрэгтэй байх шаардлагатай.
	Гүүрийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 6 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх эсвэл мэргэшсэн зэрэгтэй байх шаардлагатай.
	Геодезийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 5 жилийн ажлын туршлагатай үүнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багажнуудыг чадварлаг эзэмшдэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглаж чаддаг байх.
	Инженер-эдийн засагч-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн авто замын зураг төслийн ажилд төсөвчнөөр ажилласан байх. /Энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно/
2.8.1.2. Төв замын зураг төсөл боловсруулах /Замын байгууламжид ЗОУМ-ээс ихгүй гүүр, гүүрэн гарц, усны хоолой, авто замын хөдөлгөөнд зориулсан газар доогуурх гарц, хонгил, ус зайлуулах шүүдүү, замын хөдөлгөөний ажлуугүй байдлыг хангах	Авто замын инженер-3	Аль нэг авто замын инженер нь тухайн мэргэжлээрээ 15-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 10 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх зэрэгтэй байх шаардлагатай.
	Гүүрийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 15-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх эсвэл мэргэшсэн зэрэгтэй байх шаардлагатай.
	Геодезийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 5 жилийн ажлын туршлагатай үүнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багаж тоног төхөөрөмжийг чадварлаг эзэмшдэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглаж чаддаг байх.
	Төсөвчин-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн авто замын зураг төслийн ажилд төсөвчнөөр ажилласан, мэргэшсэн зэрэгтэй байх. /Энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./

МОНГОЛ УРСНЫ  
**ЗАМ, ТЭЭВЭРИЙН ХӨГ АЖЛЫН ЯАМ**  
**ХУУЛЬЦАР ҮЙЭН**  
 Хуучин байр болон ОХ ХУВЬ ЭВЭНЧИ ҮЕ  
*Самданзор*  
 20 21 25

<p>зориулалттай авто замын зурвас газарт байгаа бусад байгууламжууд хамаарна/</p>	<p>Зургийн техникч - 3</p>	<p>Энэ чиглэлээр 3 жилийн ажлын туршлагатай, үүнээс 1 жилд нь замын хайгуул, зураг төсөл дээр ажилласан байх.</p>
<p>2.8.1.3. Хуримтлуулагч замын зураг төсөл боловсруулах /Замын байгууламжид 6 у/м-ээс ихгүй гүүр, гүүрэн гарц, хиймэл байгууламж авто замын хөдөлгөөнд зориулсан газар доогуурх гарц, хонгил, ус зайлуулах шуудуу, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалттай авто замын зурвас газарт байгаа бусад байгууламжууд хамаарна/</p>	<p>Авто замын инженер-2</p>	<p>Аль нэг инженер нь тухайн мэргэжлээрээ 10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх эсвэл мэргэшсэн зэрэгтэй байх.</p>
	<p>Гүүрийн инженер-1</p>	<p>Тухайн мэргэжлээрээ 8-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 5 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, мэргэшсэн зэрэгтэй байх.</p>
	<p>Геодезийн инженер-1</p>	<p>Тухайн мэргэжлээрээ 5 жилийн ажлын туршлагатай үүнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийг чадварлаг эзэмшдэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглаж чаддаг байх.</p>
	<p>Төсөвчин-1</p>	<p>Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн авто замын зураг төслийн ажилд мэргэшсэн төсөвчнөөр ажилласан байх. /Энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./</p>
	<p>Зургийн техникч - 2</p>	<p>Энэ чиглэлээр 3 жилийн ажлын туршлагатай, үүнээс 2 жилд нь замын хайгуул, зураг төсөл дээр ажилласан байх.</p>
<p>2.8.1.4. Хотын авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах /Замын байгууламжид 30 у/м-ээс ихгүй гүүр, гүүрэн гарц, усны хоолой, авто замын хөдөлгөөнд зориулсан</p>	<p>Авто замын инженер-2</p>	<p>Аль нэг инженер нь тухайн мэргэжлээрээ 15-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх эсвэл мэргэшсэн зэрэгтэй байх.</p>
	<p>Гүүрийн инженер-2</p>	<p>Аль нэг инженер нь тухайн мэргэжлээрээ 10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, мэргэшсэн зэрэгтэй байх шаардлагатай.</p>
	<p>Геодезийн инженер-1</p>	<p>Тухайн мэргэжлээрээ 5 жилийн ажлын туршлагатай үүнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийг чадварлаг эзэмшдэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглаж чаддаг байх.</p>


  
**ХУУЛБАР ӨЛГӨСӨН**
  
 Хуулбар өлгөсөн

2011 оны 07 сарын 28

газар доогуурх гарц, хонгил, ус зайлуулах шуудуу, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалттай авто замын зурвас газарт байгаа бусад байгууламжууд хамаарна./	Төсөвчин-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилд төсөвчнөөр ажилласан туршлагатай, мэргэшсэн төсөвчин байх /энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./
	Зургийн техникч - 3	Энэ чиглэлээр 3 жилийн ажлын туршлагатай, үүнээс 1 жилд нь зураг төслийн ажилд ажилласан байх.
2.8.1.5. Хөдөө орон нутгийн замын зураг төсөл боловсруулах	Авто замын инженер-2	Аль нэг инженер нь тухайн мэргэжлээрээ 8-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 5 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, мэргэшсэн зэрэгтэй байх.
	Гүүрийн инженер-1	Гүүрийн инженер нь тухайн мэргэжлээрээ 8-аас доошгүй жилийн ажлын туршлагатай, тухайн чиглэлээр 5 жил ажилласан, мэргэшсэн зэрэгтэй байх.
	Геодезийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 5 жилийн ажлын туршлагатай үүнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийг чадварлаг эзэмшдэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглаж чаддаг байх.
	Төсөвчин-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилд төсөвчнөөр ажилласан байх. /Энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./
	Зургийн техникч - 1	Энэ чиглэлээр 3 жилийн ажлын туршлагатай, үүнээс 1 жилд нь зураг төслийн ажилд ажилласан байх.
2.8.1.6. Нисэх буудлын хөөрч бүх зурвасын зураг төсөл боловсруулах	Аэродромын инженер-1	Тухайн мэргэжлээрээ 10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай, тухайн чиглэлээр 8 жил ажилласан, мэргэшсэн инженер байх.
	Авто замын инженер-1	Тухайн мэргэжлээрээ 10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай, тухайн чиглэлээр 8 жил ажилласан, мэргэшсэн инженер байх.
	Геодезийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 8-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 6 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийг чадварлаг эзэмшдэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглаж чаддаг байх.
	Төсөвчин-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилд мэргэшсэн төсөвчнөөр ажилласан байх. /Энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./

	Зургийн техникч - 2	Энэ чиглэлээр 3 жилийн ажлын туршлагатай, үүнээс 2 жилд нь замын хайгуул, зураг төсөл дээр ажилласан байх.
2.8.1.7 Гүүр, туннелийн зураг төсөл боловсруулах	Гүүрийн инженер-2	Тухайн мэргэжлээрээ 15-аас доошгүй жилийн ажлын туршлагатай, тухайн чиглэлээр 10 жил ажилласан, Зөвлөх эсвэл мэргэшсэн зэрэгтэй байх. /Аль нэг нь/
	Авто замын инженер - 1	Тухайн мэргэжлээрээ 6-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 5 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, мэргэшсэн зэрэгтэй байх шаардлагатай.
	Геодезийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 5 жилийн ажлын туршлагатай үүнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийг чадварлаг эзэмшдэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглаж чаддаг байх.
	Төсөвчин-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилд мэргэшсэн төсөвчнөөр ажилласан байх. /Энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./
	Зургийн техникч - 3	Энэ чиглэлээр 3 жилийн ажлын туршлагатай, үүнээс 2 жилд нь замын зураг төслийн ажилд ажилласан байх.
<b>Шаардлагатай тоног төхөөрөмж</b>		Компьютер, тоног төхөөрөмж, Программ хангамж, Нивелир, теодолит гэх мэт геодезийн хэмжилтийн багаж, хайгуулын ажлын машин, Стандарт норм дүрэм, төсвийн норм үнэлгээ, төсөв зохиох программ хангамжтай байх.




**ХОЁР.** Авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлах ажлын хүрээнд:


Нийтлэг нөхцөл шаардлага: Ажлын туршлагатай байх /хүснэгтэнд зааснаар/

Ерөнхий нөхцөл шаардлага:


Д/Д	Нэрс ба хүчин чадал	Зөвшөөрөл авах ажлын төрөл		
		5 км хүртэл хатуу хучилттай зам барих	15 км хүртэл хатуу хучилттай зам барих	15 км болон түүнээс дээш хатуу хучилттай зам барих
		Бүх төрлийн асфальтбетон, цементбетон, хөнгөвчилсөн хучилттай авто зам, түүний их засвар, ус зайлуулах хоолой, 6 у/м хүртэлх гүүр		
<b>А.</b>	<b>Зөвшөөрөл авахад шаардагдах технологийн зориулалттай машин механизм заасан тоогоор.</b>			
1	Экскватор	1	1	2
2	Бульдозер	-	-	1
3	Автогрейдер	1	1	2
4	Ачигч	1	2	3
5	Доргиурт индүү /16 тн-оос дээш/	1	2	2
6	Хийн дугуйт индүү /10 тн-оос дээш/	-	-	1
7	Асфальтны индүү /6 тн-оос дээш/	-	1	1
8	Автогудронатор	-	-	1
9	Өөрөө буулгагч	3	5	8
10	Усны машин	1	1	2
11	Асфальт дэвсэгч	-	-	1
12	Лаборатор/иж бүрэн/	-	-	1
13	Геодезийн иж бүрдэл	-	1	1
<b>Зөвшөөрөл авахад шаардагдах мэргэжлийн ИТА-ын хамгийн бага тоогоор</b>				
1	Ерөнхий инженер	1	1	1
2	Авто замын инженер	1	2	2
3	Гүүр, хиймэл байгууламжийн инженер	-	-	1
4	Геодезийн инженер	1	1	1
5	Материалын инженер	1	1	2
<b>Б.</b>	<b>Зэрэг дэвийн нэмэлт тайлбар</b>			
1.	Нэмэлт тайлбар: Авто замын мэргэшсэн инженерийг материал, геодезийн инженер тооцож болно. Авто замын инженерийг гүүрийн барилгын ажлын туршлагыг үндэслэн гүүрийн инженер тооцож болно.	Ерөнхий инженер нь 5 жилийн ажлын туршлагатай, авто замын мэргэшсэн зэрэгтэй инженер байх, Бусад заасан инженерүүд 1-3 жилийн ажлын туршлагатай байх,	Ерөнхий инженер нь 8 жилийн ажлын туршлагатай авто замын зөвлөх эсвэл мэргэшсэн зэрэгтэй байх, авто замын 1 инженер нь 5 жилийн ажлын туршлагатай байх,	Ерөнхий инженер нь 8 жилийн ажлын туршлагатай зөвлөх эсвэл мэргэшсэн зэрэгтэй байх, Гүүр, хиймэл байгууламж, авто замын инженерүүд 5 жилийн ажлын туршлагатай аль нэг нь мэргэшсэн зэрэгтэй байх, бусад заасан инженерүүд 3-5 жилийн ажлын туршлагатай аль нэг инженер нь мэргэшсэн зэрэгтэй байх,



Д/Д	Нэрс ба хүчин чадал	Зөвшөөрөл авах ажлын төрөл		
		Хайрган хучилттай	Бүх төрлийн гүүр, тунель, газар доогуур нүхэн гарам барих	Зам барилга, засварын материал, хийцийн үйлдвэрлэл
<b>А</b>				
<b>Зөвшөөрөл авахад шаардагдах технологийн зориулалттай машин механизм заасан тоогоор.</b>				
1	Эксковатор	1	1	-
2	Автогрейдер	1	-	-
3	Ачигч	1	1	1
4	Доргиурт индүү /16 тн-оос дээш/	1	1	-
5	Өөрөө буулгагч	3	2	1
6	Усны машин /5 тн-оос дээш/	1	1	-
7	Авто Кран /25 тн-оос дээш/	-	2	-
8	Шигшүүртэй чулуу бутлуур /60 тн/цаг/	-	-	1*
9	Асфальтобетон завод /80 тн/цаг/	-	-	1*
10	Лаборатор/иж бүрэн/	1	1	1
11	Геодезийн иж бүрдэл	1	1	
12	Бетон узель	-	1	1*
<b>Зөвшөөрөл авахад шаардагдах мэргэжлийн ИТА-ын хамгийн бага тоогоор</b>				
1	Ерөнхий инженер	1	1	
2	Авто замын инженер	1	1	1
3	Гүүр, хиймэл байгууламжийн инженер		1	
4	Геодезийн инженер	1	1	
5	Материалын инженер	1	1	2
<b>Б.</b>				
<b>Зэрэг дэвийн нэмэлт тайлбар</b>				
1.	Нэмэлт тайлбар: Авто замын мэргэшсэн инженерийг материал, геодезийн инженер тооцож болно.	Ерөнхий инженер нь 5 жилийн ажлын туршлагатай, авто замын мэргэшсэн инженер байх, Бусад заасан инженерүүд 1-3 жилийн ажлын туршлагатай байх,	Ерөнхий инженер нь 5 ажлын туршлагатай гүүрийн барилгын инженер мэргэжилтэй, мэргэшсэн инженер байх, Авто зам, гүүрийн инженерүүдийн нэг нь мэргэшсэн зэрэгтэй байх,	Материалын инженерийн аль нэг нь 5 жилийн ажлын туршлагатай мэргэшсэн инженер байх, *Үйлдвэрлэлийн чиглэл тус бүрээр асфальтбетон, цементбетон, бетон хийцийн тоног төхөөрөмжийг шаардана.



Д/Д	Нэрс ба хүчин чадал	Зөвшөөрөл авах ажлын төрөл			
		Бүх төрлийн авто замын арчлалт, урсгал болон ээлжит засварын ажил	Бүх төрлийн гүүр, тунель, газар доогуур нүхэн гарам замын байгууламжийн арчлалтын ажил	Авто зогсоол, талбайн тохижилтын ажил хийх, засварлах	Замын тоноглол, тэмдэг, тэмдэглэгээний ажил
<b>А.</b>		<b>Зөвшөөрөл авахад шаардагдах технологийн зориулалттай машин механизм заасан тоогоор.</b>			
1	Эксковатор	1	1	-	-
2	Автогрейдер	1	-	-	-
3	Ачигч	1	1	1	-
4	Доргиурт индүү /10 тн-оос дээш/	-	-	-	-
5	Хийн дугуйт индүү /20 тн/	1	-	-	-
6	Асфальтны индүү	1	-	1	-
7	Өөрөө буулгагч	2	1	1	-
8	Усны машин /5 тн-оос дээш/	1	-	-	-
9	Бетон узель	-	1	-	-
10	Замын тэмдэг үйлдвэрлэх тоног төхөөрөмж, тэмдэглэгээний машин	-	-	-	1
<b>Б.</b>		<b>Зөвшөөрөл авахад шаардагдах мэргэжлийн ИТА-ын хамгийн бага тоогоор</b>			
1	Ерөнхий инженер	1	1	-	-
2	Авто замын инженер	1	-	1	1
3	Гүүр, хиймэл байгууламжийн инженер	-	1	-	-
4	Геодезийн инженер	1	1	-	-
5	Материалын инженер	1	1	1	-
<b>Б.</b>		<b>Зэрэг дэвийн нэмэлт тайлбар</b>			
1.	Нэмэлт тайлбар: Авто замын мэргэшсэн инженерийг материал, геодезийн инженер тооцож болно. Авто замын инженерийг гүүрийн барилгын ажлын туршлагыг үндэслэн гүүрийн инженер тооцож болно.	Ерөнхий инженер нь 5 жилийн ажлын туршлагатай, авто замын мэргэшсэн инженер байх, бусад заасан инженерүүд ажлын туршлагатай байх	Ерөнхий инженер нь 5 ажлын туршлагатай гүүрийн мэргэшсэн инженер байх. Бусад заасан инженерүүд ажлын туршлагатай байх	Ерөнхий инженер нь ажлын туршлагатай байх	Ажлын туршлагатай байх



ГУРАВ. Техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд:

2.8.3. Техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх	Ерөнхий инженер	Зам барилгын ажилд 15 жил, үүнээс 10-аас доошгүй жил зураг төслийн болон хяналтаар ажилласан, хяналтын инженерийн тэргүүн зэрэгтэй, зөвлөх эсвэл мэргэшсэн инженер байх
	Авто замын инженер-2	Зам барилгын ажилд 10 жил, үүнээс 3-аас доошгүй жил хяналтанд ажилласан. авто замын инженерийн мэргэжилтэй байх. Аль нэг инженер нь мэргэшсэн, хяналтын ахлах инженерийн зэрэгтэй байх.
	Гүүрийн инженер-1	Зам барилгын чиглэлээр 5 жил, үүнээс 3-аас доошгүй жил хяналтанд ажилласан, гүүрийн инженерийн мэргэжилтэй, мэргэшсэн, хяналтын ахлах инженерийн зэрэгтэй байх.
	Материалын инженер-2	Тухайн чиглэлээр 5 жил, үүнээс 3-аас доошгүй жил хяналтаар ажилласан, хяналтын ажлын туршлагатай, зам, гүүрийн инженерийн мэргэжилтэй мэргэшсэн, хяналтын ахлах инженерийн зэрэгтэй байх эсвэл дээрхи шаардлагыг хангасан барилгын материалын инженер мэргэшсэн, хяналтын ахлах инженер байх.
	Тоо хэмжээний инженер-1	Тухайн чиглэлээр 5 жил, үүнээс 3-аас доошгүй жил хяналтанд ажилласан, хяналтын ажлын туршлагатай, зам, гүүрийн инженерийн мэргэжилтэй, мэргэшсэн төсөвчин, хяналтын инженер зэрэгтэй байх.
	Хэмжилтийн инженер-1	Тухайн чиглэлээр 5 жил, үүнээс 3-аас доошгүй жил хяналтанд ажилласан, хяналтын ажлын туршлагатай, зам, гүүрийн инженер, мэргэшсэн, хяналтын ахлах инженерийн зэрэгтэй байх эсвэл геодезийн инженер мэргэшсэн, хяналтын ахлах инженерийн зэрэгтэй байх.
<b>Шаардлагатай тоног төхөөрөмж</b>		Компьютер, тоног төхөөрөмж, Программ хангамж, Нивелир, теодолит гэх мэт геодезийн хэмжилтийн багаж, хайгуулын ажлын машин, Стандарт норм дүрэм, төсвийн норм үнэлгээ, төсвийн программ хангамжтай байх.

----oOo----

